

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баяндун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны хураангуй санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2024/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4204, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Аудитын илрүүлэлт .....
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Т.Дугаар Бүс, Харин сум, Дорнод аймаг, 21000  
Эрхлэгч: Б.Баян, Утас: 7700-4202

2024.03.25 № 310

танай \_\_\_\_\_ ний № \_\_\_\_\_ -т

БАЯНДУН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Х.ХҮРЭЛЧУЛУУН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баяндун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцловсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### Аудитын гол асуудал

Тус сум нь 2023 оныг "Хүүхэд залуучуудыг дэмжих" жил болгон, хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд нийт 3 зорилтын хүрээнд 142 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан байна. Сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн 7 дугаар хуралдаанаар 91.2 хувь гэж дүгнэсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант оны 793.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна.

"Наранбулаг хөгжил" ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, "Х"-тайлан ирүүлсэн байна.

011021191

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,180,462.70	786,700.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	440,103.70	413,032.10
33	АВЛАГА	166,491.50	147,768.90
35	БАРАА МАТЕРИАЛ	573,867.60	225,899.30
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,001,519.70	3,163,096.20
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,001,519.70	3,163,096.20
39200	Биет хөрөнгө	1,906,863.60	2,799,571.50
39300	Биет бус хөрөнгө	94,656.10	363,524.80
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	3,181,982.40	3,949,796.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	3,181,982.40	3,949,796.50
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,181,982.40	3,949,796.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	651,215.00	921,215.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,088,406.90	2,586,220.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,360.60	442,360.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	3,181,982.40	3,949,796.50

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,851,995.70</b>	<b>2,751,244.80</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>567,827.20</b>	<b>771,108.20</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>422,710.20</b>	<b>470,235.20</b>
1100	Хувь хүний орлогын албан татвар	432,682.60	480,170.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,972.40	-9,935.60
113	Хөрөнгийн албан татвар	53,573.90	65,748.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	91,543.10	235,125.10
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>565,708.70</b>	<b>1,133,203.60</b>
120	Нийтлэг татварын бус орлого	542,008.70	1,112,503.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,718,459.80</b>	<b>846,933.00</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,822,441.50</b>	<b>1,153,959.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>816,702.90</b>	<b>1,057,221.90</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	367,014.80	391,747.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,113.80	46,914.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,400.30	23,103.60
2104	Хангамж, бараа материалын зардал	45,549.40	55,057.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,204.10	3,867.60
2107	Томиллолт, зочны зардал	3,448.00	10,724.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,383.80	159,602.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196,108.70	319,946.40
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	0	0
<b>212</b>	<b>ТАТААС</b>	0	0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,005,738.60	96,737.30
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	0	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,029,554.20</b>	<b>1,597,285.60</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,899,674.90</b>	<b>1,099,471.50</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-3,870,120.80</b>	<b>497,814.00</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,196,948.50	0	7,196,948.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-144,845.30	0	-144,845.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,052,103.20	0	7,052,103.20
9	Тайлант үеийн үр дүн	-3,870,120.80	0	-3,870,120.80
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,181,982.40	0	3,181,982.40
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,181,982.40	0	3,181,982.40
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,181,982.40	0	3,181,982.40
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	270,000.00	0	270,000.00
19	Тайлант үеийн үр дүн	497,814.00	0	497,814.00
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	3,949,796.50	0	3,949,796.50

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,384,041.00</b>	<b>1,699,750.60</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	567,827.20	771,108.20
110	Орлогын албан татвар	422,710.20	470,235.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	432,682.60	480,170.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,972.40	-9,935.60
113	Хөрөнгийн албан татвар	53,573.90	65,748.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	91,543.10	235,125.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,044.80	5,405.60
1181	Газрын төлбөр	47,298.50	212,314.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	38,199.80	17,405.10
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	97,754.10	81,709.40
120	Нийтлэг татварын бус орлого	74,054.10	61,009.40
122	Тусламжийн орлого	23,700.00	20,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,718,459.80	846,933.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,668,572.80</b>	<b>839,136.60</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	662,834.20	742,399.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	367,014.80	391,747.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,113.80	47,046.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,473.00	23,103.60
2104	Хангамж, бараа материалын зардал	32,650.50	39,864.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,785.00	6,440.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,383.80	159,602.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,965.30	62,517.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,005,738.60	96,737.30
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>715,468.20</b>	<b>860,614.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	653,589.90	887,685.60
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	653,589.90	887,685.60
2200	Дотоод эх үүсвэрээр	653,589.90	887,685.60
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-653,589.90	-887,685.60
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-84,000.00	0
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	84,000.00	0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-22,121.70</b>	<b>-27,071.60</b>
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	462,225.30	440,103.70
20	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	440,103.70	413,032.10

**БАЯНДУН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,978,143.4</b>	<b>1,634,995.1</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	821,683.6	740,309.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	788,120.7	723,572.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,141.6	390,120.2
210101	Үндсэн цалин	281,773.5	265,586.8
210102	Нэмэгдэл	79,473.3	96,875.3
210104	Урамшуулал	31,894.8	26,867.4
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	770.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,724.9	47,045.9
210201	Тэтгэврийн даатгал	33,405.0	32,388.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,466.0	3,495.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,901.5	3,752.3
210204	Ажилгүйдлийн даатгал	820.8	814.5
210205	Эрүүл мэндийн даатгал	7,131.6	6,595.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,817.3	159,622.3
210301	Гэрэл, цахилгаан	76,148.6	75,935.3
210302	Түлш, халаалт	83,959.8	80,978.2
210303	Цэвэр, бохир ус	2,708.9	2,708.8
2104	Хангамж, бараа материалын зардал	31,848.7	30,085.3
210401	Бичиг хэрэг	3,328.8	3,793.5
210402	Тээвэр, шатахуун	23,948.8	22,050.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,142.1	1,873.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,429.0	2,367.9
2105	Нормативт зардал	1,356.5	1,354.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,356.5	1,354.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,282.8	16,133.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	492.9	491.8
210604	Урсгал засвар	15,789.9	15,641.6
2107	Томилолт, зочны зардал	10,635.7	10,184.0
210702	Дотоод албан томилолт	10,635.7	10,184.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,336.7	8,974.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,064.2	5,814.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,440.0	1,440.0
210807	Газрын төлбөр	1,832.5	1,720.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,976.5	60,052.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,976.5	60,052.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,562.9	16,737.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,562.9	16,737.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737.4	16,737.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,825.5	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,073,459.8	894,685.6
223001	Бусад хөрөнгө	1,073,459.8	894,685.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	83,000.0	0
230001	Эргэж төлөгдөх зээл	83,000.0	0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,978,143.4</b>	<b>1,741,071.7</b>
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,504,203.4	1,430,274.4
320001	Орон нутгийн төсвөөс	726,383.6	694,821.9
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	777,819.8	735,452.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	435,900.0	290,097.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,800.0	53,703.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.0	600.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	403,500.0	235,793.4
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0	0
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	38,040.0	20,700.0
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	38,040.0	20,700.0
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	178,656.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		284,732.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	47,223.0	98,826.7
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	47,223.0	98,826.7
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,223.0	18,826.7
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,736.0	1,626.9
210104	Урамшуулал	1,736.0	1,626.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.0	4,415.9
210301	Гэрэл, цахилгаан		4,415.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,453.6	9,778.9
210401	Бичиг хэрэг	595.0	246.0
210402	Тээвэр, шатахуун	2,108.6	8,278.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	750.0	1,254.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	0.0	540.0
210702	Дотоод албан томилолт	0.0	540.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,033.4	2,465.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,033.4	2,465.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	40,000.0	80,000.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,000.0	80,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,000.0	80,000.0
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	47,118.0	98,826.8
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,118.0	98,826.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,457.6	96,616.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,660.4	2,210.6
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 808.9 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

- Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Орон нутгийн хөрөнгө оруулалтын 20.0 сая төгрөгийн 1, ОНХС-гийн 107.0 сая төгрөгийн 4 арга хэмжээ /Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, арчилгаа -20.0 сая, Наранбулаг хөгжил ОНӨААТҮГ -17.0 сая, Малын угааврын ванн -40.0 сая, "Нэг сум- нэг үүлдэр" малын үүлдэр сайжруулах -30.0 сая/-г огт хэрэгжээгүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
- Тайлант оны 793.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3. Наранбулаг хөгжил" ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, "Х"-тайлан ирүүлсэн, удирдлагыг нь томилоогүй байна. Сумын Засаг дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаарх Засаг даргын бүрэн эрх: 78 дугаар зүйлийн 2.2-д "орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох", 2.3-д "орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн

Илрүүлэлт: Малын тоо толгойн албан татварын орлого гүйцэтгэлээр 49.3 сая төгрөг орж 23.9 хувь буюу 15.5 сая төгрөгөөр тасарсан байна. Малын тоо толгойн албан татварын орлогоор 82.0 сая төгрөгийн 5 ажил хийхээр төлөвлөснөөс 70.0 сая төгрөгийн 2 арга хэмжээ /Малын угааврын ванн -40.0 сая, "Нэг сум- нэг үүлдэр" малын үүлдэр сайжруулах - 30.0 сая/ хийгдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг нэр төрлөөр нь ханган ажиллах зөвлөмж өгөв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна	1	00			1	0							
Малын тоо толгойн албан татварын орлогыг 23.9 хувиар тасарсан	1	15.5					1	15.5		-		-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>15.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>15.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**БАЯНДУН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс				
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>							
-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>							
ХАА-ны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй	1	793.5			1	793.5	
"Наранбулаг хөгжил" ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, Х тайлан ирүүлсэн.	1	0	-	-	1	0	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>793.5</b>	-	-	<b>2</b>	<b>793.5</b>	-
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>793.5</b>	-	-	<b>2</b>	<b>793.5</b>	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 01/99 дор-2024/12/111-срн-013  
А 0160305

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн төсвийн болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 127.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баяндун сумын Засаг дарга Х.Хүрэлчулуун, санхүү албаны дарга П.Энхчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *Шүмэг* И.СЭМЖИДМАА  
АХЛАХ АУДИТОР *Нармандах* Д.НАРМАНДАХ



011041335



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 02/100 ДДН-2024/10/НА-СН-ТБС Чойбалсан хот  
А0160305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 793.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим дэлгүүрт худалдан авах ажиллагааны жагсаалтыг байршуулах хүсэлтийг хүргүүлэх, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баяндун сумын Засаг дарга Х.Хүрэлчулуун, санхүү албаны дарга П.Энхчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

 М.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

 Д.НАРМАНДАХ

211714056  
ХТҮ-027 500031

011041332



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 03/101 ДДА-2024/02/НА-СТА 925 Чойбалсан хот

А1160305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Наранбулаг хөгжил” ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, “Х”-тайлан ирүүлсэн, удирдлагыг нь томилоогүй байна.

Сумын Засаг дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаарх Засаг даргын бүрэн эрх: 78 дугаар зүйлийн 2.2-д “орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох”, 2.3-д “орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. “Наранбулаг хөгжил” ОНӨААТҮГ-ын удирдлагыг томилон, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баяндун сумын Засаг дарга Х.Хүрэлчулуун, санхүү албаны дарга П.Энхчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



И.СЭМЖИДМАА  
Д.НАРМАНДАХ

011041328